

2026 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны
хуралдааны төлөвлөгөөг батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.28 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны хуралдааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /О.Батчулуун/, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Б.Гэрэлзул/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Б.АРТУР

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026
оны 01 дүгээр сарын 30 -ны өдрийн
...01... дүгээр тогтоолын хавсралт



**“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛААР 2026 ОНД ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ, АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

д/д	Хэлэлцэх асуудал, ажлын төлөвлөгөө	Хугацаа	Хариуцах нэгж
1.	Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар 2026 онд хэлэлцэх асуудлын жагсаалт, ажлын төлөвлөгөө батлах тухай	01 сар	ЗУГ, ТУЗ-ийн Ажлын алба
2	Ногдол ашиг хуваарилах эсэх тухай	Хуулийн хугацаа 02.18-ны дотор	СХОТГ
3	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай	Хуулийн хугацаа 03.20-ны дотор	ТУЗ-ийн Ажлын алба
4.	Компанийн 2025 оны Бизнес төлөвлөгөө, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл, аудитлагдсан санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны тайлангийн талаар дүгнэлт гаргаж, Хувьцаа эзэмшигчид мэдэгдэх тухай	03-04 сар	Захиргаа, удирдлагын газар, СХОТГ
5	Гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг дүгнэх тухай	03-04 сар	Захиргаа, удирдлагын газар
6	Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн төмөр замын төслийн явц, ажлын гүйцэтгэл, санхүүжилт болон холбогдох бусад асуудлыг хэлэлцэх тухай	Тухай бүр	Төсөл хөтөлбөр, судалгааны газар
7	Компанийн 2025 оны үйл ажиллагаанд хийсэн аудитаар өгсөн албан даалгавар, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний биелэлтийн тухай	05, 08 сар	Хяналтын алба
8	Компанийн хэмжээнд мөрдөгдөх нэгдсэн нэг тарифыг батлуулах /Цогтцэций-Зүүнбаян чиглэлд ачааны бүлгээс хамаарсан тарифтай болох/	Эхний хагас жилд	СХОТГ, Тээврийн удирдлагын газар
9	Компанийн балансад бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг актлах тухай	06 дугаар сар	СХОТГ

10	Компанийн урт болон дунд хугацааны стратеги төлөвлөгөө, Бизнес төлөвлөгөөний хэрэгжилт	Хагас, бүтэн жилээр	СХОТГ
11	Компанийн 2027 оны Бизнес төлөвлөгөө, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тухай	11-12 сар	СХОТГ
12	Компанийн хэрэгжүүлж буй төслүүдтэй холбоотой шийдвэр гаргах болон төлөвлөгөөнд тусгагдаагүй, цаг үеийн шинжтэй тулгамдсан асуудал, ТУЗ-ийн бүрэн эрхийн хүрээнд хамаарах бусад асуудал	Тухай бүр	Хариуцсан газар, хэлтэс